НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/57 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрөлийн чиглэл хасах, тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн тусгай зөвшөөрлийн комиссын хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 10 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл хасах 1 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар, тусгай зөвшөөрөл сунгах 4 хуулийн этгээдийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

4.Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д тус тус даалгасугай.

1526010205

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.НАРАНБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 02 дугаар сарын 23 -ны өдрийн
А/57 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	Рашаантун ХХК /5579007/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	Баянгол дүүргийн 12-р хороо, Хасбаатарын гудамж, 7/3 байрны 1 давхар
2.	Эмнэт сор ХХК /7228065/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	Баянгол дүүргийн 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16100/, Товчооны зам гудамж, 5-р байр, 1 давхарын өргөтгөл
3.	Миш мар фарм ХХК /7242457/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	Хан-Уул дүүргийн 15-р хороо /17009/, Нарны зам гудамж, 8/2-р байр, 4А тоот
4.	Эс Би Эс ХХК /2048353/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, 4-р байр 2-р орц 0 тоот хаягтай
5.	Аз ТЭСА ХХК /6980481/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Сэтгэцийн өвчний тусламж, үйлчилгээ	Баянгол дүүргийн 3-р хороо Грейс төвийн 5 давхарт
6.	Визүм оптик ХХК /6647154/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Нүдний өвчний тусламж, үйлчилгээ	Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн гудамж, 12А тоот
7.	Новамайнд диагноз ХХК /7176193/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Дүрс оношилгоо /MRI/	Баянзүрх дүүргийн 43-р хороо, 13-р хороолол, Манлайбаатар Дамдисүрэнгийн гудамж, 85/1
8.	Глобал удирдагч их сургуулийн дэргэдэх эмнэлэг ХХК /7255497/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Дотор, Мэдрэл, Эмэгтэйчүүд, Хүүхдийн өвчний тусламж, үйлчилгээ	Сүхбаатар дүүргийн 11-р хороо Глобал удирдагч их сургуулийн байрны 1 давхарт /Ногоон нуурын 51/
9.	Геном днх ХХК /8437173/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Лабораторийн оношилгоо /клиник хими, гематологи, биохими, иммунологи, удамзүй, молекул биологи, генетикийн шинжилгээ/	Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Үйлдвэр /17034/, Чингисийн өргөн чөлөө гудамж, 77/4-р байр, 3 давхарт, 304 тоот

10.	Эрчис медикал ХХК /7225369/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Дотрын өвчний тусламж,үйлчилгээ, Дүрс оношилгоо /ЭХО/, Лаборатори ононшилгоо	Хан Уул дүүрэг, 15 хороо, Рапид харш хотхон, Нийслэл хүрээ өргөн чөлөө гудамж, 31-р байр, 1 тоот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 23 -ны өдрийн
А/57 дугаар тушаалын хөёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ ХАСАХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөлд хасах чиглэл	Үндэслэл
1.	Ану мед ХХК /60044113/	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	Шүдний өвчний гажиг засал	2026 оны 03 срын 12-ны өдрийн шинжээчийн дүгнэлтээр

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 25 -ны өдрийн
А/57 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

9025101255 СТС6091 9077456

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Үйл ажиллагааны чиглэл	Сунгалт хийх хугацаа	Үндэслэл
ЭМИЙН САН				
1.	Есү-энх ХХК /5297028/	Лабораторийн оношилгоо	2031.03.29	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/49 дугаар тушаалаар хяналт шалгалт хийсэн мэргэжилтэн Э.Энхзаяа, А.Эрбахыт нарын 80.4% үнэлсэн дүгнэлтийг үндэслэв.
2.	Гэрэгэ толгой ХХК /6872816/	Хөнгөвчлөх асаргаа сувилгаа төв	2031.03.29	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/40 дугаар тушаалаар хяналт шалгалт хийсэн мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ, Ц.Чогзол нарын 83% үнэлсэн дүгнэлтийг үндэслэв.
3.	Ачит билгүүн энх ХХК /6877176/	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	2030.12.30	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/350 дугаар тушаалаар хяналт шалгалт хийсэн улсын байцаагч Б.Тэргэлсаран, Б.Болормаа нарын 80.6% үнэлсэн дүгнэлтийг үндэслэв.
4.	Мөнгөн дент ХХК /6127428/	Шүдний өвчний тусламж үйлчилгээ, Нүүр амны согог засал	2030.08.02	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар хяналт шалгалт хийсэн улсын байцаагч О.Дэлгэрцэцэг, Ж.Номин-Эрдэнэ нарын 83% үнэлсэн дүгнэлтийг үндэслэв.